



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР

2017 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх,
хянах ажлыг эрчимжүүлэх тухай

Тархвар судлалын 41 дэх 7 хоногийн байдлаар улсын хэмжээнд амбулаторит суурилсан тандалтаар 153,355 хүн үйлчлүүлсний 6,483 (4.2%) нь томуу, томуу төст өвчин гэж оношлогдсон нь өмнөх 7 хоногоос 0.3 хувиар, сүүлийн 3 жилийн дунджаас 0.4 хувиар их байна. Нийслэлийн хэмжээнд амбулаториор 63,235 хүн үйлчлүүлсний 4.5% нь томуу, томуу төст өвчин гэж оношлогдсон нь өмнөх 7 хоног болон сүүлийн 3 жилийн дунджаас 0.2%-иар их байна.

Өнгөрсөн оны томуу, томуу төст өвчний дэгдэлтийн оргил үед улсын хэмжээнд амбулаторийн нийт үзлэгийн 11 хувь, нийслэлийн үзлэгийн 12.2 хувийг томуу, томуу төст өвчний шалтгаантай үзлэг эзэлж байсан. Мөн нийслэлийн хэмжээнд ажиллаж байгаа хүүхдийн 789 оронд нэмэлтээр 392 ор дэлгэж ажилласан хэдий ч оргүйн улмаас эмнэлгийн коридор, шалан дээр хэвтэн эмчлүүлсэн талаар иргэд олон нийтийн шүүмжлэл гарч байсан.

Иймд хүйтний улирал эхэлж, томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед эмнэлгийн хүүхдийн орны ачаалал эрс нэмэгдэж, ор хүрэлцэхгүйгээс хүүхэд эмнэлгийн коридор шалан дээр хэвтэн эмчлүүлэх зөрчил дутагдал гаргахгүй байхад онцгой анхаарч, доорх үйл ажиллагааг шуурхай хэрэгжүүлэхийг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, тусгай эмнэлэг, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт **ДААЛГАСУГАЙ.**

1. Томуу, томуу төст өвчний үед авах арга хэмжээний бэлэн байдал, шуурхай удирдлагаар хангах чиглэлээр:

1.1. Эрүүл мэндийн сайдын 2014 оны 358 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 346, 395 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах;

1.2. Томуу, томуу төст өвчний тандалт судалгааг эрчимжүүлэх;

1.3. Томуу, томуу төст өвчнийг угтуулан болон томуу, томуу төст өвчний үед авах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байнгын бэлэн байдлын төлөвлөгөөг нягталж, тодотгол хийж, уг өвчний дэгдэлтийн үед эмнэлгийн тасаг нэгжүүдийн үйл ажиллагааг зохицуулах, нэмэлт ор дэлгэх, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг дайчлах талаар судалгаа гарган, эргэн мэдээлж, хяналттай ажиллах;

1.4. Сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийн эмчийн үзлэгийг гэрийн үйлчилгээнд шилжүүлэх;

080006

1.5. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үе шаттай уялдуулан түргэн тусламж үзүүлэх эмч, эмнэлгийн мэргэжилтэн, автомашиныг нэмэлтээр гаргах, сум, тосгон өрхийн эрүүл мэндийн төвийн болон амбулаторийн үзлэгийн цагийг уртасгах болон эмч, мэргэжилтнийг илүү цагаар ажиллуулах асуудлыг тусламж, үйлчилгээний шатлал бүрт зөв зохистой зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

1.6. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг томуу, томуу төст өвчний үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр сургалт, давтан сургалтад хамруулан, шинэ мэдээллээр тогтмол хангаж ажиллах;

1.7. Амбулаторийн үзлэгт томуу, томуу төст өвчин 15-аас дээш хувийг эзэлж, улсын хэмжээнд дэгдэлт гарах үед цэцэрлэг, сургууль зэрэг хүүхдийн байгууллагуудыг түр хаах, үзвэр, үйлчилгээ, нийтийн цуглааныг хязгаарлах арга хэмжээг бусад байгууллагуудтай хамтран шийдвэрлэх;

1.8. Томуу, томуу төст өвчний үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэрэгжилтийн байнгын хяналтыг сайжруулж, хариу арга хэмжээг шуурхай авах;

1.9. Холбогдох мэдээ, мэдээлэл, тайланг батлагдсан журмын дагуу мэдээлж, эргэх холбоог тогтмолжуулж ажиллах;

1.10. Албан даалгаврын хэрэгжилтийг долоо хоног тутмын Баасан гарагийн 16.00 цагт Халдварт өвчин судлалын үндэсний төвийн (ХӨСҮТ) Томуугийн тандалтын нэгжид цахимаар (Eop@nccd.gov.mn), ХӨСҮТ нь дараа долоо хоногийн Даваа гарагийн 16.00 цагийн дотор Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газарт цахимаар болон цаасан хэлбэрээр ирүүлэх.

2. Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх чиглэлээр:

2.1. Томуугийн эсрэг сайн дурын дархлаажуулалтад эрүүл мэндийн байгууллагын ажилтан, жирэмсэн эмэгтэй, 5 хүртэлх насны хүүхэд, ахмад настан, эрсдэлт бүлгийн хүн амыг хамруулах;

2.2. Жирэмсэн эмэгтэй, хүүхэд, ахмад настан, эрхтэн тогтолцооны эмгэг, архаг хууч өвчтэй эрсдэлт бүлгийн хүн амыг тодорхойлж, сум, тосгон өрхийн эмчийн хяналтыг сайжруулан, урьдчилан сэргийлэх үзлэгийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, нөөцийг зөв, зохистой хуваарилж, хүргэх;

2.3. Лабораторид шаардлагатай оношлуур, урвалж бодисын нөөцийг бэлэн болгох;

2.4. Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай эм, бэлдмэл, тоног төхөөрөмжийн хангамж, хүрэлцээ, бэлэн байдлыг хангах;

2.5. Эмч нарт вирусын эсрэг ямар эм, эмийн бэлдмэлийг хэрэглэх, томуугийн вирус хүн амын дунд идэвхтэй эргэлтэд орсон үед вирусын эсрэг эм(тамифлю)-ийг хүндэрч болзошгүй, хүнд өвчтөнд зааврын дагуу хэрэглэх талаар сургалт зохион байгуулах.

3. Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх чиглэлээр:

3.1. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг томуу, томуу төст өвчний эргэн мэдээллээр хангах;

3.2. Сургууль, цэцэрлэгийн эмч анги, танхимаар өдөр бүр идэвхтэй эргэлт хийж, хүүхдүүдэд өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөж, тусламж үзүүлэн, томуу, томуу төст өвчний зовиуртай, халуурч, ханиалгаж байгаа хүүхдийг хичээлээс нь чөлөөлөх;

3.3. “Томуу, томуу төст өвчний халдвараас сэргийлье” мэдээлэл, сурталчилгааг иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, орон нутгийн төрийн, төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүдтэй хамтран, хэвлэл мэдээллийн бүх хэрэгсэл/суваг/ -ийг ашиглан зохион байгуулах;

3.4. Дархлаа сайжруулах цэгэн иллэгийг хүүхэд бүрт хийж хэвшүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

3.5. Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх зөвлөмжийг ард иргэдэд сурталчилж, мөрдүүлэн хэвшил болох.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ